

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүх шинжилгээний хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2025/107/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2024 он

Дарга, Тэргүүлэх аудиторын албан тушаалын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Энхтөр
Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.17 № 52
танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ШҮҮХ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА
П.ЦОГБАДРАХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүх шинжилгээний хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүх шинжилгээний хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.9, 8 дугаар зүйлийн 8.1, 8.1 дахь зүйлүүдэд зааснаар тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцасны талаарх хязгаарлалтад хамрагдаагүй.

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн нийт зарлагыг 352.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 352.5 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 46.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 399.2 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч тухайн онд ажлын байр нүүсэнтэй холбогдуулан түлш халаалтын зардал, шинээр 1 орон тоо нэмж батлагдсан тул түүний цалин хөлсийг нэмж, үндсэн хөрөнгө бэлтгэх саналыг хасаж баталсан байна.

Шүүх шинжилгээний хэлтэс нь 2024 оны санхүүгийн тайлангаар нэмэлт

632502037

санхүүжилтийн дансаар 1.0 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 1.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ

6317144798
ГТ0А0048 3190269

